

ТАНИЛЦУУЛГА

Цагийн бүртгэл хөтлөх, аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлагын талаар

Цахим гарын үсгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт “Цагийн бүртгэл хөтлөх, аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлагыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.” гэж заасан. “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны Зорилт 5.3-ын 5.3.1 дүгээрт “Мэдээллийн аюулгүй байдлын, цахим гарын үсгийн, мэдээллийн сангийн, хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын зэрэг цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардагдах хууль тогтоомжийг боловсруулж батлуулан, түүнтэй нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна.” гэж заасны дагуу энэхүү шаардлагын баримт бичгийн төслийг боловсрууллаа.

Монгол Улсад одоо ашиглагдаж байгаа нийтийн түлхүүрийн дэд бүтэц нь 2014 онд байгуулагдсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын байдлаар нийт 899,783 тоон гарын үсгийг олгосон байна.

Одоо байгаа дэд бүтэц нь цагийн бүртгэлийн систем байхгүй бөгөөд түүнтэй холбоотой харилцааг зохицуулах бодлого журам батлагдаагүй байна. Манай улсад одоо ашиглагдаж байгаа дэд бүтцийн хувьд цагийн бүртгэлийн системийг нэгтгэж өгөөгүй тул гарын үсэг зурж байгаа этгээдийн тоон гарын үсийг цаг хугацааны хувьд баталгаажуулалт хийх боломжгүй байна. Өөрөөр хэлбэл хэрэглэгч өөрийн ашиглаж буй төхөөрөмж /компьютер, таблет г.м/-ийн цагийг өөрчлөх замаар тоон гарын үсийг аль ч хугацаанд өөрийн хүссэнээр зурах боломжтой. Иймд нийтийн түлхүүрийн дэд бүтцийг зохион байгуулахад цагийн бүртгэлийн системийг нэгтгэж өгөх шаардлагатай бөгөөд түүнээс урьтаж эрх зүйн орчныг тодорхой болгох шаардлагатай.

Журмын төслийг 4 бүлэгтэйгээр боловсруулсан бөгөөд Нэгдүгээр бүлэгт ерөнхий зүйлсийг тодорхойлж, хоёрдугаар бүлэгт цагийн бүртгэлийн систем хариуцах байгууллагын үүргийг тодорхойлсон.

Гуравдугаар бүлэгт цагийн бүртгэлийг үүсгэх, түүнийг баталгаажуулах гарын үсгийн хувийн болон нийтийн түлхүүрийг үүсгэж, түүнийг аюулгүй хадгалах үй ажиллагааг тодорхойлсон.

Дөрөвдүгээр бүлэгт цагийн бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тодорхойлж, цагийн бүртгэл хөтлөх, систем, сүлжээнд тавигдах аюулгүй байдлын шаардлагыг тодорхойлсон.

Энэхүү журам батлагдсанаар иргэн, хуулийн этгээд цахим гарын үсэг ашиглаж баталгаажуулалт хийх үед цахим баримт бичиг, төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн цахим үйлчилгээнд цагийн бүртгэлийг хугацааны хувьд нарийвчилсан, нууцлалтай, хүртээмжтэй байдлаар хөтлөх боломж бүрдэнэ.

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

---o0o---

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2024 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

Дугаар ...

“ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ”

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэг, Цахим гарын үсгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“ Цагийн бүртгэл хөтлөх, аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлагын”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Харилцаа холбооны зохицуулах хороонд тус тус үүрэг болгосугай.

САЙД

Н.УЧРАЛ

ЦАГИЙН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нэг. Ерөнхий

1.1. Энэхүү баримт бичгийн зорилго нь тоон гарын үсгийн цагийн бүртгэлийн гэрчилгээ үүсгэх, шалгах түүний аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Цаг бүртгэлийн хэрэглэгч нь хуулийн этгээд эсхүл хүн байна.

1.3. Цагийн бүртгэлийн системийг Үндэсний дата төв Улсын Төсөвт Үйлдвэрийн Газар /цаашид "Бүртгэлийн байгууллага" гэх/-т байршуулна.

1.4. Цагийн бүртгэлийн системийн хувийн түлхүүрийг цагийн бүртгэлийн токен /цаашид "токен" гэх/-д гарын үсэг зурахад ашиглана.

/Тайлбар: Токен гэж баталгаажуулах үйлдэл хийгдсэн цаг, огноо болон бусад шаардлагатай мэдээллийг агуулсан, тэдгээрийн үнэн, зөвийг нотлох зорилготой цахим өгөгдлийг/

Хоёр. Үүрэг, хариуцлага

2.1. Цагийн бүртгэлийн системийн хэвийн найдвартай үйл ажиллагаа, аюулгүй байдлыг бүртгэлийн байгууллага хариуцан ажиллана.

2.2. Бүртгэлийн байгууллага олон улсын стандарт, холбогдох хууль, дүрэм журамд нийцсэн Цагийн бүртгэлийн үйл ажиллагааны журам /цаашид "үйл ажиллагааны журам" гэх/-ыг баталж, мөрдөнө.

2.3. Цагийн бүртгэлийн системд холбогдоход бүртгэлийн байгууллагатай гэрээ байгуулна.

4.1. Бүртгэлийн байгууллага цагийн бүртгэл үүсгэхтэй холбоотой үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

Гурав. Цагийн бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд тавигдах шаардлага

3.1. Цагийн бүртгэлийн систем нь RFC 3161 - Internet X.509 Public Key Infrastructure Time-Stamp Protocol (TSP) стандартад нийцсэн байна.

/Тайлбар: "RFC 3161" гэж "Интернэтийн инженерчлэлийн мэргэшсэн баг/IETF/-ийн боловсруулсан цагийн бүртгэлийн протоколын стандартыг/

3.2. Бүртгэлийн байгууллага өөрийн хөрөнгө, тэдгээрт үүсэж болох аюул заналыг тодорхойлох зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийнэ.

3.3. Бүртгэлийн байгууллагын төлөөлөх эрх бүхий этгээд үйл ажиллагааны журмыг батална.

3.4. Бүртгэлийн байгууллага өөрийн болон дараах мэдээллийг хэрэглэгчид ил тод байлгана.

- 3.4.1.үйл ажиллагааны журам;
- 3.4.2.үйлчилгээний нөхцөл шаардлага;
- 3.4.3.холбоо барих мэдээлэл;
- 3.4.4.цагийн бүртгэлийн бодлого;
- 3.4.5.цагийн бүртгэл үүсгэж байгаа алгоритм;
- 3.4.6.токенд ашиглагдаж байгаа гарын үсгийн хүчинтэй хугацаа;
- 3.4.7.үйлчилгээний хамрах хүрээ;
- 3.4.8.хэрэглэгчийн үүрэг;
- 3.4.9.токеныг шалгах арга замууд;
- 3.4.10.үйлдлийн бүртгэлийн хадгалах хугацаа;
- 3.4.11.хууль эрх зүй;
- 3.4.12.талуудын хүлээх хариуцлага;
- 3.4.13.маргаан шийдвэрлэх.

3.3. Хувийн болон нийтийн түлхүүрийг үүсгэж, хадгалах

3.3.1. токеныг баталгаажуулах гарын үсгийн хувийн түлхүүрийг бүртгэх байгууллагад үүсгэж, дараах байгууллагын төлөөллийг оролцуулан, үүсгэсэн талаар тэмдэглэл үйлдэж баталгаажуулна:

- 3.3.1.1.цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
- 3.3.1.2.Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Үндэсний төв;
- 3.3.1.3.Бүртгэх байгууллага.

3.3.2. токеныг баталгаажуулах хувийн түлхүүрийг үүсгэж, хадгалах криптограф модул нь дараах шаардлагыг хангасан байна:

- 3.3.2.1. FIPS 140-1 3 болон түүнээс дээш түвшний;
- 3.3.2.2. CWAgreement 14167-2, эсхүл;
- 3.3.2.3. ISO 15408 дагуу EAL 4-г хангасан систем.

3.3.4. токеныг баталгаажуулах гарын үсгийн гэрчилгээ нь нийтийн түлхүүрийг агуулсан байна.

3.4. Цагийн бүртгэл үүсгэх

3.4.1. цагийн бүртгэл аюулгүй, амжилттай хийгдсэн эсэхийг Бүртгэлийн байгууллага шалгаж, баталгаажуулна.

3.4.2.токен цагийн бүртгэлийн хэрэглээ, шаардлагыг тодорхойлсон, дахин давтагдашгүй дугаартай байна.

3.4.3.токенд бичигдэх цагийн утга нь Координатжуулсан дэлхийн цаг /UTC/-тай синхрончлогдсон байна.

Дөрөв. Цагийн бүртгэл хөтлөхөд аюулгүй байдлыг хангах

4.1. Бүртгэлийн байгууллага кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам, халдлага зөрчилд хариу үзүүлэх төлөвлөгөөг баталж, мөрдөнө.

4.3. Мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хуульд заасны дагуу хийлгэж, тайланг холбогдох байгууллагад хүргүүлнэ

4.2. Бүртгэлийн байгууллага цагийн бүртгэлийн системийн хэвийн найдвартай ажиллагааг тогтмол хангаж, өөрчлөлт оруулах, сүлжээг өргөтгөхөд бүртгэл хөтөлнө.

4.5. цагийн бүртгэлийн үйлчилгээ үзүүлэхдээ гуравдагч этгээдийн үйлчилгээ авах бол аюулгүй байдлыг хангахтай холбоотой үүрэг хариуцлагыг тодорхойлно.

4.6. Энэ журмын 4.2-т систем, сүлжээнд хамаарах тоног төхөөрөмжийг Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журмын 4.4-т заасан өрөөнд байрлуулж, зөвхөн энэ журмын 3.3.1-т заасан этгээд хандана.

---oOo---